



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/32

Пионер толгой

“Өөрчлөлтийг хурдасгая” уриан дор
“Дэлхийн усны өдөр”-ийг тэмдэглэн
өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны 2/7 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.1.4, 5.2 дахь заалт, Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/135 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Өөрчлөлтийг хурдасгая” уриан дор “Дэлхийн усны өдөр”-ийг 2023 оны 03 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2.“Дэлхийн усны өдөр”-ийг тохиолдуулан олон талт арга хэмжээг зохион байгуулж, иргэд, сурагчдад сурталчилан ажиллахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (Ш.Нархүү), Байгаль хамгаалагч (М.Бат-Эрдэнэ) нарт даалгасугай.

3.Дээрх арга хэмжээнд шаардагдах 250.000 (Хоёр зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас тооцож олгохыг Тамгын газрын дарга (Р.Гантулга), нягтлан бодогч (Б.Дэлгэрдалай) нарт зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Р.Гантулга)-д даалгасугай.



ДАРГА  Б.ГАНТУЛГА

642201241